

**БАТЛАВ:**

"БАГАНУУР" ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Доржийн  
Сомбат  
272110001

Р.НОМИНЧУЛУУН

**БАТЛАВ:**

"АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ"  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ш. БАЯНМОНХ

**НҮҮРС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

2022 оны 11 р сарын 28-ний өдөр

Дугаар 22/13-15

Багануур дүүрэг

35/2022

**Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1. "Амгалан Дулааны Станц" ТӨХК-ийн Зуухны түлш бэлтгэх тоноглолд гэрээний 2.1-д заасан стандартын шаардлагад нийцсэн нүүрсийг гэрээнд заасан хуваарийн дагуу "Багануур" ХК-аас худалдах, "Амгалан дулааны станц" ТӨХК худалдан авч төлбөр тооцоо хийх ажиллагааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.2. "Багануур" ХК /цаашид Худалдагч гэх/ нь "Амгалан дулааны станц" ТӨХК /цаашид Худалдан авагч гэх/-д гэрээний хугацаанд **10.00** мян.тонн (Арван мянган) нүүрсийг хавсралтанд заасан хуваарийн дагуу гэрээнд заасан үнээр нийлүүлнэ.
- 1.3. Багануур ХК-ны борлуулах нүүрсний үнийг эрх бүхий байгууллагаас нэмсэн тохиолдолд тухайн тогтоолыг үндэслэн гэрээнд өөрчлөлт оруулан нэмэгдсэн өдрөөс эхлэн шинэчилсэн үнийг мөрднө.
- 1.4. Худалдан авагч нь гэрээний хугацаанд **10.00** мян.тонн (Арван мянган) нүүрсийг хавсралтанд заасан хуваарийн дагуу гэрээнд заасан нөхцлөөр хүлээн авна.
- 1.5. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах аль нэг талын саналыг энэхүү гэрээнд оролцогч талууд хамтран шийдвэрлэнэ. Шийдвэрийг бичгээр үйлдэж гэрээнд хавсаргана. Хавсралт нь гэрээний адил хүчин төгөлдөр мөрдөгднө.

**Хоёр. Худалдагчийн үүрэг, эрх, хариуцлага**

- 2.1. Худалдагч нь худалдан авагчийн технологийн шаардлагад тохирсон, сарын дундаж илчлэг нь 3360.0 ккал/кг-аас доошгүй, 0-300 мм-ийн бутлагтай, шавар, чулуулгын хольцын хэмжээ нь 3%-иас ихгүй, үнслэг, чийглэг нь MNS 3818- 2001 стандартад зааснаас ихгүй нүүрсийг гэрээнд заасан хуваарийн дагуу нийлүүлэх үүрэгтэй. Нүүрсний стандарт шинээр батлагдсан тохиолдолд түүнийг дагаж мөрднө.
- 2.2. Худалдагч нь нүүрсийг вагонд нүүрс ачих паспортын дагуу ачиж өөрт суурилагдсан, улсын байцаагчаар баталгаажсан вагон жингээр жигнэж, Худалдан авагчийн хаягаар баримтыг бурдуулж явуулна.  
Вагон жингийн зөвшөөрөгдөх зөрүүг Худалдан авагчтай хамтран тогтоолгож зөвшөөрөгдөх зөрүүнд өөрчлөлт гарсан тохиолдолд Стандартчилал Хэмжил Зүйн Газраар зөвшөөрөгдсөн төмөр замын этalon жингээр улсын байцаагчийн оролцоотойгоор тогтоолгоно.
- 2.3. Нүүрсний ширхэглэгийн хэмжээ болон чанар зөрчигдөх, вагоны ачилт дундуур ирсэн тохиолдолд гарах хохирлыг Худалдагчийн чанарын инженер, эсвэл бусад эрх бүхий төлөөлөгч, Худалдан авагчийн төлөөлөгч газар дээр нь очиж гэрээнд холбогдох хүмүүсийг байлцуулан акт тогтоож шийдвэрлэнэ. Шаардлагатай гэж үзвэл Ашигт малтмалын газрын судалгаа шинжилгээний лабораторийн шинжилгээг үндэслэн шийдвэр гаргана.

БАГАНУУР  
СОРСЫГ БҮР  
2022 он 11 сар 6

- 2.4. Худалдагч нь өөрийн сорыц авах хүмүүсийг “ДЦС-3”ТӨХК-аас авч ирэн ажиллуулах ба Худалдан авагчийн сорыц бэлтгэгчтэй хамтран хоёр тал стандартын дагуу цуваа бүрээс сорыц авч “Амгалан дулааны станц” ТӨХК, “Багануур Илч” ХХК-ний лабораторуудад шинжилүүлж шинжилгээний дүнгийн дунджаар илчлэгийг тооцно. Лаборатори тус бүр сарын дундаж илчлэгээ арифметикийн дунджаар гаргана.
- 2.5. Худалдагч нь ажил олгогчийн хувьд сорыц авагч нарын хөдөлмөрийн аюулгүй байдал, зааварчилгааны хэрэгжилт, сорыц авах техник ажиллагааны мөрдөлтийг бүрэн хариуцна.
- 2.6. Худалдагч нь сайтар цэвэрлэсэн вагонд нүүрс ачих ажлыг Төмөр замын өртөөтэй хамтран зохион байгуулна. Хэрэв төмөр, экскаваторын шүд, эд анги ачигдаж станцын тоноглолд гэмтэл учруулбал хоёр талын эрх бүхий техникийн комисс хамтран акт тогтоож шийдвэрлэнэ.
- 2.7. Худалдагч нь УБТЗ-н вагон үзэгч нартай хамтран үзлэг хийж гэмтэлтэй вагонд нүүрс ачихгүй байх үүрэг хулээнэ.
- 2.8. Нүүрстэй хамт тээвэрлэгдэж ирсэн гадны биетээс болж /чулуу, төмөр/ бутлуур болон тоноглол эвдээрсэн нь 2.6-д заасан техникийн комиссоор тогтоогдвол Худалдагч тал засварлах зардлыг хариуцна.
- 2.9. Худалдагч талын падаан бичигч нь төмөр замын Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем(АТҮЦС) программ ашиглан бичиг баримтуудыг цахимаар солилцож үнэн зөвөөр бичиж хугацаанд нь Худалдан авагчид илгээнэ. Энэ нь тооцоо нийлэх үндсэн баримт болно. Хэрэв АТҮЦС нь ажиллагаагүй болсон тохиолдолд бичиг баримтыг цаасаар бичиж явуулна.
- 2.10. Худалдагч нь гэрээнд заасан нүүрсээ нийлүүлж чадахгүй тохиолдолд 7-14 хоногийн өмнө, Худалдагчийг төлөөлж давагдашгүй хүчин зүйл гарвал 7 хоногийн дотор Худалдан авагчид албан ёсоор мэдэгдэнэ.
- 2.11. Худалдагч нь Худалдан авагчийн зуух, түлш дамжлагын тоноглолд нүүрстэй хамт их хэмжээний гадны биет ачиж тоноглолд гэмтэл учруулахгүй байх үүрэгтэй.
- 2.12. Худалдан авагч нь гэрээний хавсралтанд заасан хуваарийг өөрчлөн захиалгаа өгсөнөөс шалтгаалан гэрээний биелэлтэнд сөргөөр нөлөөлсөн бол үүнээс гарах хохирлыг Худалдагч хариуцахгүй.
- 2.13. Худалдан авагчаас шалтгаалан гэрээний хавсралтанд заасан хуваарийн дагуу нүүрс худалдан аваагүй бол Худалдагч нөхөн нийлүүлэхгүй байж болно.
- 2.14. Худалдагч талаас шалтгаалан нүүрсээ хуваарийн дагуу нийлүүлж чадаагүй тохиолдолд Худалдан авагчийн саналыг үндэслэн нийлүүлээгүй нүүрсийг дараа саруудад нөхөн нийлүүлнэ.
- 2.15. Худалдан авагч нь нүүрсний үнийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд 7 хоногийн өмнө албан ёсоор мэдэгдэж нүүрс нийлүүлэлтийг хязгаарлах, зогсоох эрхтэй.
- 2.16. Худалдагч нь нүүрсийг вагоны даацанд хүргэж ачих үүрэг хулээнэ.
- 2.17. Дулааны станцын төмөр замын хүчин чадалд тааруулж өртөөнөөс нүүрстэй вагоныг тогтмол 8 буюу 16 вагоныг өдөр, шөнийн ээлжинд 8 вагоны цуваагаар явуулж байна.

#### **Гурав. Худалдан авагчийн эрх, үүрэг, хариуцлага**

- 3.1. Худалдагчаас ирүүлсэн нүүрсийг хулээн авахдаа вагоны дагалдах бичиг, бичигдсэн падааны дагуу вагоны дугаар, бутармаг, жингээр нь тулган хүлээн авна.
- 3.2. Худалдагчийн нийлүүлсэн нүүрс гэрээний 2.1-д заасан шаардлага хангагүй буюу үүний улмаас хэрэглэгчийн тоноглолд saatал, хохирол гарах тохиолдолд Худалдагчийн төлөөлөгчийг байлцуулан дор дурьдсан журмаар асуудлыг шийдвэрлэнэ. Үүнд:
  - 3.2.1 2900 ккал/кг-аас доош илчлэгтэй, 300 мм фракцаас дээш ширхэглэгтэй нүүрсийг хулээж авахгүй, нүүрстэй вагоныг Худалдагчийн төлөөлөгчид хүлээлгэн өгч

буцаана. Энэ тохиолдолд хаяг солихтой холбогдон гарах тээврийн бүхий л зардлыг Худалдагч хариуцна.

- 3.2.2 Худалдан авагчын вагон хөмрөгчийн мэдрэгчид нөлөөлж тухайн нүүрстэй вагон буухгүй бол хаяг солих асуудлыг УБТЗ-д тавьж шийдвэрлүүлэх ба холбогдон гарах тээврийн бүхий л зардлыг Худалдан авагч өөрөө хариуцна.
- 3.2.3 2900 ккал/кг-аас дээш илчлэгтэй, 300 мм-ээс доош ширхэглэгтэй нүүрсийг Худалдан авагчийн техникийн шаардлага хангасан гэж үзэж ямар нэгэн нэмэгдэл зардал гаргахгүйгээр хүлээн авна.
- 3.2.4 Нүүрсний чанартай холбоотой маргааныг таслах зорилгоор Худалдагч, Худалдан авагч хамтран сорьц авч шинжилж эцсийн шийдвэр гаргаж болох бөгөөд шинжилгээний дүнг гаргал зогссон вагоны ашиглалт, таталт тавилтын хөлс, хаяг солилтын хөлс, холбогдож гарах бусад зардлыг буруутай тал хариуцна.
- 3.2.5 Нийлүүлэгдсэн нүүрсний төмөр, шавар чулуулгийн хольцын хэмжээ гэрээний 2.1-д зааснаас их байсан тохиолдолд нүүрсний хэмжээнээс хасаж тооцно.
- 3.3. Энэхүү гэрээний хавсралтанд заасан нүүрс нийлүүлэх хуваарийг үндэслэн Худалдагчтай тодотгол хийсний дараа Худалдан авагч нь сар бүрийн 20-ны дотор вагон захиалах төлөвлөгөөт гэрээг УБТЗ-ын Тээвэр зохтон байгуулалтын албанад өгч батлуулж ажиллана. Нүүрсний тээврлэлтэнд зориулсан вагоноор хангах асуудлыг УБТЗ-д тавьж шийдвэрлүүлж ажиллана.
- 3.4. Диспетчерийн Үндэсний Төв /ДҮТ-ХК/-аас өгсөн дулааны хэрэглээний өсөлтөөс болж Худалдан авагч нь гэрээний хавсралтанд заасан хуваарыт өөрчлөлт оруулах шаардлагатай болсон тохиолдолд Худалдагчтай зөвшилцсөний дараа төмөр замын байгууллагад вагоны захиалга өгнө. Харин өвлийн их ачааллын үед нөөцлөх нүүрсийг ЭХЯ-аас баталсан тохиолдолд уг хуваарийг Худалдагчтай тохиролцон мөрднө.

### **Дөрөв. Төлбөр, тооцоо**

- 4.1. Тухайн сарын эхний өдрийн 00 цагаас сарын сүүлчийн өдрийн 24.00 цагийн хооронд ачсан нүүрс вагоны тоог төмөр замын явуулах өртөөний /Багануур өртөө/ календарийн тэмдгийг ачааны падаанд дарсан он, сар, өдрөөр авч сарын тооцоог 2 тал хийнэ.
- 4.2. Худалдан авагч нь сарын хуваарыт нүүрсний төлбөрийн 30%-50%-ийг тухайн сарын эхний 15 хоногт багтаан нэхэмжлэхээр төлөх ба сард нийлүүлэгдсэн нүүрсний нийт төлбөрийг дараа сар эхлэхээс өмнө төлж дууссан байх үүрэгтэй.
- 4.3. Багануур өртөөнөөс Амгалан өртөө-Амгалан дулааны станц хүртэлх вагоны тээврийн зардлыг Худалдан авагч тал хариуцна.
- 4.4. Сард нийлүүлсэн нүүрсний жинг тооцоходо:
- 4.4.1. Худалдагч болон Худалдан авагч талын Стандарт Хэмжилзүйн Газраар баталгаажсан вагон жингийн дундаж заалтаар тооцоо хийнэ.
- 4.5. Төмөр замын тээврийн хөлсийг станц, төмөр замын өртөөний хооронд сар бүр хийсэн тооцоог үндэслэн Худалдан авагч төлж нүүрс тээврийн захиалга өгөх нөхцлийг бүрдүүлнэ. Төмөр замд төлбөр хийгдээгүйн улмаас вагон хангальтаас үүдсэн хохирлыг Худалдан авагч бүрэн хариуцна. Нүүрс болон вагон захиалганд зохицуулалт хийвэл харилцан хоорондоо урьдчилан мэдэгдэнэ. Тээврийн хөлсийг Худалдагч тал явуулах өртөөнд төлөхгүй.
- 4.6. Энэхүү гэрээний хавсралтанд заасан хуваарийн дагуу Худалдан авагч тухайн сард авсан нүүрсний төлбөрийн үлдэгдлийг дараа сарын 20-ны дотор төлж ажиллана. Урьд сарын дутуу төлөлтийг төлж дууссаны дараа тухайн сарын төлбөр хийгдсэн гэж үзнэ.
- 4.7. Төлбөрийг хугацаандаа хийгээгүй бол үлдэгдэл төлбөрийн дүнгээр хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.15 хувиар бодож Худалдагчид алданги төлнө. Алдангийн хэмжээ сарын нийт үнийн дүнгийн 20 хувиас хэтрэхгүй байна.

- 4.8. Худалдагчийн буруугаас нүүрс нийлүүлэлт, татан авалтын гэрээний үүрэг тасарсан тохиолдолд дутуу нийлүүлсэн нүүрсний үнийн дүнгийн 0.15 хувиар бодож Худалдан авагчид алданги төлнө. Алдангийн хэмжээ нийт үнийн дүнгийн 20 хувиас хэтрэхгүй байна.
- 4.9. Төлбөр төлөлт болон нүүрс нийлүүлэлтийн дутуугаас тооцох алдангийг гэрээний хугацаа дууссаны дараа гэрээ дүгнэх хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 4.10.Худалдагч, Худалдан авагчийн буруутай бус шалтгаанаар нүүрс нийлүүлэлт, татан авалтын гэрээний үүрэг тасарсан тохиолдолд төмөр замд нүүрс тээвэрлэлтийн талаар хамтарсан акт бичнэ.
- 4.11.Нийлүүлэх нүүрсний суурь илчлэгийг 3360 ккал/кг-аар тооцоонд авах бөгөөд 1 тонн технологийн дамжлагын нүүрсний үнийг 33500 төгрөг, 1 ккал/кг-ын үнийг 9.970 төгрөгөөр, 1 тонн цэгийн нүүрсний үнийг 32500 төгрөгөөр, 1ккал/кг-ын үнийг 9.673 төгрөгөөр тус тус тооцно. Нэмэгдсэн өргтийн албан татварыг нэмж тооцно.
- Нүүрсний илчлэг 3360 ккал/кг-аас доош орсон буюу дээш гарсан илчлэгтэй нүүрсний үнийг тооцоходоо тухайн сарын дундаж илчлэгийг 1ккал/кг-ын үнээр үржүүлж бодно. Уурхай болон Дулааны станцын удирдлагын зөвшөөрлөөр ТЭЦ-4-өөс хаяг сольж 2900ккал/кг-аас бага илчлэгтэй нүүрс нийлүүлэгдвэл тухайн нүүрсэнд илчлэгийн зөрүү тооцно. 3500 ккал/кг-аас дээш илчлэгтэй нүүрсэнд илчлэгийн зөрүү тооцохгүй.
- 4.12.Нүүрсний үнэд эрх бүхий дээд газруудаас өөрчлөлт оруулсан үед өөрчлөгдсөн үнийг өөрчлөлт орсон өдрөөс эхлэн мөрдөж ажиллана.
- 4.13.Харилцан хүлээх хариуцлагаас үүдэн гарах хохирлын тооцоог гэрээ дууссаны дараа хийнэ. Сар бурийн нүүрс нийлүүлэлтийн тооцооны дүнг хэлэлцсэн протокол болон хохирол saatlyн актыг Худалдагчийн тооцооны ня-бо, чанарын инженер нар танилцаж гарын үсэг зурна. Гарсан хохирлын актыг тухайн улирлын аж ахуйн гэрээг дүгнэхдээ хоёр талын эрх бүхий албан тушаалтнууд баталгаажуулан харилцан суутгал хийж тооцно.
- 4.14.Талууд сарын хуваарийн дагуу вагон захиалалт, нийлүүлэлт, татан авалтыг шуурхай гүйцэтгэж гэрээний үүргээ биелүүлэх ба энэ талаар аль нэг талын буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлыг буруутай тал нь хүлээнэ.

#### **Тав. Гэрээний бусад нөхцөл**

- 5.1. Талууд өөрсдийн захиалгаар арбитр лабораторийн нэмэлт шинжилгээ хийлгэвэл шинжилгээний үнийг захиалсан тал төлнө.
- 5.2. Цаг агаарийн дулаарагал, хэрэглэгчийн дулааны хэрэглээний хязгаарлалтаас болж Худалдагчийн борлуулалт тасарч үүний улмаас нүүрсний хэрэглээ багасвал гэрээг Худалдан авагчийн татан авсан нүүрсний хэмжээгээр биелсэнд тооцно. Торгууль хүлээлгэхгүй. Аль нэг талдаа төлөгдөх алдангийн хэмжээ нь сарын төлбөл зохих нийт төлбөрийн 20 хувиас хэтэрч болохгүй.
- 5.3. Хэрэглэгчдийн дулааны хэрэглээний төлөвлөгдөөгүй өсөлтөөс болж аж ахуйн гэрээнээс илүү нүүрс Худалдан авагчийн технологийн хэрэгцээнд зайлшгүй шаардагдвал 20 хоногийн өмнө Худалдагчид мэдэгдэн энэхүү гэрээний хавсралтанд заасан нүүрсний хуваарьт албан тоотоор өөрчлөлт оруулж мөрдөнө. Нүүрсний үнийг гэрээнд заасан үнээр тооцно.
- 5.4. Технологийн saat, аваарь осол гарах, техникийн хүндрэл учрах зэрэг тохиолдолд гэрээ хийсэн талуудын төлөөлөгчид хамтран хэлэлцэж саадыг даван туулах, гэрээний заалтанд өөрчлөлт оруулах шийдвэрийг бичгээр гаргана. Энэ шийдвэр нь гэрээний эцсийн биелэлтэнд нөлөөлөхгүй.
- 5.5. Нүүрс нийлүүлэлт нь вагон хангамжаас шалтгаалах тул тухайн сард төмөр замаас нийлүүлэн ачсан вагоны хэдэн хувийг Худалдан авагчид илгээсэн, Худалдан авагч

тухайн сард нийт вагоны хэдэн хувийг захиалсан харьцааг үндэслэн Худалдагч, төмөр замын хэн буруутайг тогтооно.

5.6. Энэхүү гэрээ нь харилцан баталсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

5.7. Талууд гэрээний заалтуудыг тогтмол мөрдэж ажиллах бөгөөд гэрээтэй холбоотой маргаан гарвал 2 тал аль болох эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв тохиролцохгүйд хүрвэл шүүхэд асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ.

5.8. Гэрээг улирал бүр дүгнэх бөгөөд 2022 оны I, III улирлыг Худалдагч тал, II, IV улирлыг Худалдан авагч хариуцан очиж дүгнэнэ. Энэхүү гэрээ нь 2022 оны 02 дугаар сарын 20 -ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр мөрдөгденэ.

5.9. Гэрээ хүчин төгөлдөр болж мөрдөгдсөн өдрөөс хойши хугацаанд хүчин төгөлдөр байх ба цаашид сунгах эсэх асуудлыг хугацаа дуусахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Гэрээнд оролцогч аль нэг тал нь гэрээг үргэлжлүүлэн мөрдөхөөс татгалзаагүй тохиолдолд хүчин төгөлдөр гэж үзнэ.

5.10. Энэхүү гэрээ нь Худалдагчид 1 хувь, Худалдан авагчид 2 хувь тус бүр хадгалагдах бөгөөд гэрээ дүгнэсэн акт, протоколын хувиудыг талууд өөрсдөө хадгална. Гэрээ дүгнэсэн акт, протокол нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно. Нийлүүлэх нүүрсний хэмжээ, төлбөрийн тооцоог хавсралтаар гаргаж баталгаажуулав.


### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


Тэргүү дэд захирал

 Д. Түвшинжаргал

СЭЗБХ-ийн дарга

 Д. Болд

Үйлдвэр борлуулалтын албаны дарга


 Т. Бямбажаргал

Хуулийн зөвлөх

 С. Сэргэлэн

#### ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер

 Э. Мөнжаргал


СЭЗХ-ийн дарга, ерөнхий ня-бо түр орлон гүйцэтгэгч

 О. Урдвал


Ахлах инженер

 Б. Батцоож

Түлш дамжуулах цехийн дарга

 Д. Түвшинзаяа

Хуулийн мэргэжилтэн

 Г. Саруул

#### ТАЛУУДЫН ХАЯГ:

Улаанбаатар хот, Багануур дүүрэг  
8-р хороо,  
“Багануур” ХК  
Утас 0121-21-130, 21230, 20734  
Факс: 0121-21-130, 0121-21-230  
Данс: ХХБанк 499031495  
ХААН Банк 5750009138  
ХАС Банк 5000199440

Улаанбаатар хот. Баянзүрх дүүрэг  
8 дугаар хороо Ус-15-1-1  
“Амгалан дулааны станц”-ТӨХК  
Утас: 99047300, 99662289  
Факс: 77111253  
Данс: ХХБ 464018009  
Капитрон Банк: 2010030479

....тоот гэрээний хавсралт

2022 оны 02-р сарын 20 –ний өдрөөс 2022 оны 12-р сар дуусталх хугацаанд "Багануур" ХК-иас  
"Амгалан дулааны станц"ТӨХК-д нийлүүлэх нүүрсний хуваарь

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 он							Нийт дүн /тн /
			01-р сар	02-р сар	03-р сар	04-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	
	Зуухны тоо		3	3	2	1	2	3	3	
1	Нийлүүлэх боломжит нүүрс	тонн	0	1 500	6 500	2 000	0	0	0	10 000
2	Дүн	тонн								

Хуваарь гаргасан:

"БАГАНУУР" ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ҮЙЛДВЭР БОРЛУУЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА

Т. БЯМБАЖАРГАЛ

"АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ"-ТӨХК-ИЙН  
АХЛАХ ИНЖЕНЕР

Б. БАТЦООЖ